

1/13/22, 12:26 PM

Цахим Парламент

Хэвлэсэн: А.Цээпил [Бичиг хэргийн ажилтан]

Хэвлэсэн огноо: 2022-01-13 12:26:48

ИРСЭН БАРИМТ БИЧГИЙН БҮРТГЭЛ

Бүртгэсэн		Хаанаас, хэнээс ирүүлсэн	Хэнд хандсан	Ирсэн бичгийн			Тэргүү товч утга
Огноо	Бүртгэлийн дугаар	Монгол Улсын Засгийн газар	Г.Занданшатар	Дугаар	Огноо	Хуудас, ботийн тоо	Зөвшилцөх тухай
2022-01-13	22/315			ЗГ-1/10	2022-01-13	73	

Удирдлагын заалт

Улсын Их Хурлын Тамгын газар

- 1 АБГБВХ-нь дараа В.Батболд, ТБХ-нь дараа
- 2 Г.Кулбаатар, ЗЗБХ-нь дараа Н.Гансүхтүцэг
- 3 БАНВМ-нь хяналтын хуалдаар хэлэлцэн
- 4 үзэн ажлын үр

Эзэн авсан он..... сар..... өдөр цаг минут

Гарын үсэг





МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

20 ᠒᠒ он ᠒᠒
сарын 13 өдөр

Дугаар 35-1/1᠐

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
Г.ЗАНДАНШАТАР ТАНАА

Зөвшилцөх тухай

Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээрүүд (Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, тогтвортой мал аж ахуйг хөгжүүлэх төсөл)-ийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр хүргүүлж байна.

Улсын Их Хурлын Байнгын хороодын хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

Монгол Улсын Ерөнхий сайд



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

000224000039

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдааны 3 дугаар тэмдэглэлд:

“ХИ.ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээрүүд (Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, тогтвортой мал аж ахуйг хөгжүүлэх төсөл)-ийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээрүүд (Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, тогтвортой мал аж ахуйг хөгжүүлэх төсөл)-ийн төслийг хэлэлцээд Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

ТАНИЛЦУУЛГА

*Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк
хамтран хэрэгжүүлэх "Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй,
тогтвортой мал аж ахуйг хөгжүүлэх төсөл"-ийн тухай*

Төслийн зорилго: Төслийн зорилго нь уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, тогтвортой, үр ашигтай мал аж ахуйн хөгжлийг бий болгоход оршино.

Төсөл хэрэгжүүлэгч: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

Төсөл хэрэгжих хугацаа: 2021 - 2027 он.

Төсөл хэрэгжих газар: Булган, Архангай, Өвөрхангай, Баянхонгор 4 аймгийн хил залгаа 20 сум:

- Булган: Гурванбулаг, Хишиг-Өндөр, Могод, Сайхан (4 сум)
- Архангай: Эрдэнэмандал, Хайрхан, Батцэнгэл, Өлзийт, Өгийннуур, Хашаат (6 сум)
- Өвөрхангай: Баруунбаян-Улаан, Гучин-Ус, Нарийнтээл, Тарагт, Хайрхандулаан (5 сум)
- Баянхонгор: Баян-Овоо, Эрдэнэцогт, Өлзийт, Жинст, Богд (5 сум).

Төсөвт өртөг: Нийт 34.50 сая ам.доллар /Үүнээс Азийн хөгжлийн банк (АХБ)-ны зээлийн санхүүжилт 30.0 сая ам.доллар/

Төслийн хүрээнд хийгдэх гол ажлууд:

1. **Уур амьсгалыг тэсвэрлэх чадвар, менежментийг сайжруулах.** Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд цаг уурын эрс тэс үзэгдлийн давтамж нэмэгдэж буйтай холбогдуулан малчдын уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадварыг нэмэгдүүлнэ. Бэлчээрийн менежмент нь хөрсний нүүрстөрөгчийн шингээлтийн гол хүчин зүйл бөгөөд үүний үр дүнд нийт төслийн хүрээнд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулна. (i) 11,660 малчдыг хамарсан 466 бэлчээр ашиглах гэрээ байгуулж, 466 малчдын бүлгийг бий болгосноор бэлчээрийн менежмент, нөөцийн хэмжээг сайжруулна; (ii) малчдад зориулан 14,000 малын хашаа хороог сайжруулна; (iii) 382 шинэ усны худаг барих, сэргээн засварлах, 466 ус ашиглах гэрээг байгуулж малын ундны усны хүртээмжийг сайжруулна; (iv) 466 малчдын бүлэгт зориулан 14,000 хадлангийн талбай, өвсний агуулах барих замаар малын тэжээлийг сайжруулна; (v) 20 сумын бэлчээрийн нөөц газар байгуулах.

2. **Мал аж ахуйн нэмүү өртгийн сүлжээг бэхжүүлэх.** Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд мал аж ахуйн нэмүү өртгийн сүлжээний оролцогчдын уялдаа холбоо, зохицуулалтыг сайжруулахын зэрэгцээ мал сүрэг, бүтээгдэхүүний чанар, эрүүл мэндийн стандартыг сайжруулах болно. Төсөлд хамрагдсан малчид нэг малаас илүү өндөр ашиг хүртэж, улмаар тооноос илүү чанар руу шилжих боломжтой. Энэ нь бэлчээрт үзүүлэх дарамт, нөлөөллийг бууруулж, Монгол Улсад мал аж ахуйн илүү тогтвортой хөгжлийн загвар руу шилжих боломжийг олгоно. Энэ нь мал аж ахуйн нэмүү өртгийн сүлжээг дараах замаар сайжруулснаар хэрэгжинэ: (i) 2,915 малчин өрх болон боловсруулагчдын хооронд холбоо тогтоож мал аж

ахуйн маркетингийг сайжруулах ба малчдад эргүүлээд санал хүсэлт өгөх тогтолцоог бий болгох; (ii) хадлан бэлтгэх, тэжээл хадгалах ажлыг дэмжих замаар 466 малчдын бүлгийн малыг тэжээх; (iii) 54 мал эмнэлгийн чадавхыг сайжруулах замаар 11,660 малчны малын эрүүл мэндийг сайжруулах; (iv) хонь, ямааны 20 орчим цөм сүрэг байгуулах замаар малын үржлийг сайжруулах; (v) Хурга бордох 20 тэжээлийн хэсэг байгуулах замаар малын эргэлтийг сайжруулах; (vi) сумдад ноолуур ангилах 20 байгууламж байгуулах замаар ноолуурын маркетинг, борлуулалтыг сайжруулах.

3. Мал аж ахуйн салбарын зохицуулалтын хүрээ ба чадавхыг сайжруулах. Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд (i) бэлчээрийн менежментийг сайжруулахад чиглэсэн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, мэдлэгийг дээшлүүлэх, сурталчлах үйл ажиллагааг хөгжүүлэх замаар мал аж ахуйн зохицуулалтын тогтолцоо, байгууллагын чадавхыг бэхжүүлэх; (ii) Газар зүйн мэдээллийн системд суурилсан Мал аж ахуйн менежментийн мэдээллийн систем болон ХХААХҮЯ-нд Бэлчээр, тэжээлийн хэлтэс байгуулах; (iii) зах зээлийн жишигт хүргэхийн тулд малын махны чанар, гарал үүслийг тодорхойлох, хариу өгөх системийг боловсруулах; (iv) 20 суманд Монгол улсын малын эрүүл мэндийн мэдээллийн системийг өргөжүүлэх; (v) ХХААХҮЯ-ны Судалгаа, хөгжлийн төвийн өргөтгөл, сургалтын чадавхыг сайжруулах; (vi) гурван аймаг дундын бэлчээрийн нөөц газрыг хөгжүүлэх.

Төсөл хэрэгжүүлэх үндэслэл, шаардлага:

Сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлтөд өртөж байгаа улсуудын дунд Монгол улс дээгүүр орох болсон бөгөөд цөлжилт, ган, зуд, хаврын салхин болон цасан шуургын давтамж нэмэгдэж, Монгол улсын эдийн засгийн гол салбарын нэг болох мал аж ахуйн салбарт сөрөг нөлөөг бодитойгоор үзүүлж байна. Монгол улсад нийт 180 мянга орчим малчин өрх байгаа бөгөөд хүн амын 30 гаруй хувийн амьжиргааг залгуулж байгаа энэхүү салбарт тогтвортой, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, үр ашигтай байх шаардлага зайлшгүй тулгарч байна. Мөн бэлчээрийн даац байж болох хэмжээнээс 2-3 дахин хэтэрсэн байгаа нь энэхүү салбарт үр ашигтай бодлого, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлагыг бий болгосон. Үүний дагуу АХБ-наас энэхүү төслийг хэрэгжүүлснээр Малчдад байгалийн нөөцийг хадгалан мал сүргээ өсгөхөд чиглэсэн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх бөгөөд мал аж ахуйн салбарын бүтээмжийг нэмэгдүүлэх зуд гэх мэт байгалийн гамшигт өртөмтгий байдлыг бууруулах, цөөн малтай иргэд амьжиргаагаа залгуулах боломжгүй болж хот суурин газар руу шилжих хөдөлгөөнийг нэмэгдүүлж байгаа асуудлыг шийдвэрлэх зэрэг болно.

Төсөл нь харьцангуй бага ашиглагдсан бэлчээрийг хамгаалах, даац хэтэрсэн хэсгийг зохицуулалт хийх замаар удирдах, малын сүргийн бүтэц, малын эрүүл мэндийн үйлчилгээ, үүлдэр угсааг сайжруулах, малын гаралтай бүтээгдэхүүний борлуулалтыг хангах зэрэгт хөрөнгө оруулалт хийх шаардлагатай байна. Төсөл нь 4 аймгийн 20 суманд хэрэгжүүлэхээр зорьж байгаа бөгөөд цаашдаа үндэсний хэмжээнд өргөжүүлэх боломжтой юм. Төслийн хүрээнд орон нутагт чадавхи бэхжүүлэх ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулахаар төлөвлөгдсөн.

Бодлогын баримт бичигт туссан байдал:

Доор дурдсан бодлогын баримт бичгүүд болон холбогдох шийдвэрүүдэд тусгагдсан болно.


- "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 8.3.4, 8.3.5 дэх заалтад тусгагдсан.
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.4, 3.3.7 дах заалт
- "Монгол Мал" үндэсний хөтөлбөрийн "Хоёр."-ийн 4 зэрэг заалтууд тус тус болно.

Төслийн хүлээгдэж буй үр дүн:

2028 он гэхэд төсөлд хамрагдсан 11,660 малчны орлого нэмэгдсэн байх ба 4.78 сая га, өндөр бүтээмж бүхий бэлчээрийн газрыг малчид ашиглах боломжтой болж, уст цэг болон бэлчээрт үзүүлж буй дарамтыг бууруулсан байна.

Төслийн талбай:

- Булган: Гурванбулаг, Хишиг-өндөр, Могод, Сайхан (4 сум)
- Архангай: Эрдэнэмандал, Хайрхан, Батцэнгэл, Өлзийт, Өгийнуур, Хашаат (6 сум)
- Өвөрхангай: Баруунбаян-Улаан, Гучин-Ус, Нарийнтээл, Тарагт, Хайрхандулаан (5 сум)
- Баянхонгор: Баян-Овоо, Эрдэнэцогт, Өлзийт, Жинст, Богд (5 сум).



Төсөвт өртгийн задаргаа: Зардлын нарийвчилсан тооцоо

Зардлын ангилал	Сая ам.доллар			Суурь зардлын %
	Гадаад валют	Дотоод валют	Нийт	
A. Хөрөнгө оруулалтын зардал				
a. Барилгын ажил	4.10	6.15	10.24	34.00%
b. Тоног төхөөрөмж, материал	7.55	1.33	8.88	29.49%
c. Зөвлөх үйлчилгээ	1.56	1.56	3.12	10.36%
d. Үр шим хүртэж буй талын оролцоо	0.00	2.43	2.43	8.05%
Дэд дүн (A)	13.21	11.46	24.67	81.90%
B. Урсгал зардал				
a. Төслийн удирдлага	0.15	1.32	1.46	4.86%
b. Сургалт ба хэлэлцүүлэг	0.08	0.76	0.84	2.79%
c. ТУН ба ТХН Үйл ажиллагааны зардал	0.00	3.03	3.03	10.07%
d. ЗГ-ийн оролцоо	0.00	0.12	0.12	0.38%
Дэд дүн (B)	0.23	5.22	5.45	18.10%
Нийт суурь дүн (A+B)	13.44	16.68	30.12	100.00%
C. Магадлашгүй зардал				
a. Магадлашгүй зардал	1.25	1.23	2.49	8.26%
b. Үнийн өөрчлөлтийн магадлашгүй зардал	0.32	0.35	0.67	2.24%
Дэд дүн (C)	1.58	1.58	3.16	10.49%
D. Хэрэгжилтийн явцын хүү, шимтгэл	1.22	0.00	1.22	4.06%
Төслийн нийт зардал (A+B+C+D)	16.24	18.27	34.51	114.56%

Зардлын ангилал	Нийт зардал	Үр дүн 1		Үр дүн 2		Үр дүн 3		Үр дүн 4	
		Дүн	Зардлын ангилал эзлэх %	Дүн	Зардлын ангилал эзлэх %	Дүн	Зардлын ангилал эзлэх %	Дүн	Зардлын ангилал эзлэх %
A. Хөрөнгө оруулалтын зардал									
a. Барилгын ажил	10.24	6.09	59.4%	3.90	38.0%	0.14	1.4%	0.12	1.2%
b. Тоног төхөөрөмж, материал	8.88	4.13	46.5%	2.67	30.1%	1.57	17.7%	0.51	5.8%
c. Зөвлөх үйлчилгээ	3.12	0.48	15.4%	0.00	0.0%	2.58	82.7%	0.06	1.9%
d. Үр шим хүртэгч талын оролцоо	2.43	2.43	100.0%	0.00	0.0%	0.00	0.0%	0.00	0.0%
Дэд дүн (A)	24.67	13.12	53.2%	6.57	26.6%	4.29	17.4%	0.69	2.8%
B. Урсгал зардал									
a. Төслийн удирдлага	1.46	0.00	0.0%	0.00	0.0%	0.00	0.0%	1.46	100.0%
b. Сургалт ба хэлэлцүүлэг	0.84	0.00	0.0%	0.00	0.0%	0.84	100.0%	0.00	0.0%
c. ТУН ба ТХН Үйл ажиллагааны зардал	3.03	0.00	0.0%	0.00	0.0%	0.99	32.6%	2.04	67.4%
d. ЗГ-ын оролцоо	0.12	0.00	0.0%	0.00	0.0%	0.00	0.0%	0.12	100.0%
Дэд дүн (B)	5.45	0.00	0.0%	0.00	0.0%	1.83	33.6%	3.62	66.4%
Нийт суурь зардал (A+B)	30.12	13.12	43.5%	6.57	21.8%	6.12	20.3%	4.31	14.3%
C. Магадлашгүй зардал									
a. Магадлашгүй зардал	2.49	1.05	42.0%	0.66	26.4%	0.44	17.8%	0.34	13.8%
b. Үнийн өөрчлөлтийн зардал	0.67	0.37	55.5%	0.20	29.5%	0.04	6.7%	0.06	8.3%
Дэд дүн (C)	3.16	1.42	44.9%	0.86	27.1%	0.49	15.4%	0.40	12.6%
D. Хэрэгжилтийн үеийн хүү, шимтгэл	1.22	0.45	36.4%	0.29	23.8%	0.30	24.3%	0.00	0.0%
Төслийн нийт зардал (A+B+C+D)	34.51	14.98	43.4%	7.71	22.4%	6.91	20.0%	4.71	13.7%

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ЗЭЭЛИЙН ДУГААР ____МОН

МОНГОЛ УЛС


болон

АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК
хоорондын

ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР
(Энгийн үйл ажиллагаа)

(Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, тогтвортой мал аж ахуйг хөгжүүлэх төсөл)

ОГНОО _____



ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР (Энгийн үйл ажиллагаа)

МОНГОЛ УЛС (цаашид "Зээлдэгч" гэх) болон АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК (цаашид "АХБ" гэх) хооронд _____-ны өдөр байгуулсан ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭРЭЭР

Талууд дараах зүйлсийг харилцан тохиролцож:

(А) Зээлдэгч нь энэхүү зээлийн хэлэлцээрийн Хуваарь 1-д дурдсан төслийг хэрэгжүүлэх зорилгоор АХБ-нд хандан зээл авах хүсэлт гаргасан (цаашид "Төсөл" гэх);

(В) Зээлдэгч нь Зээлдэгч болон АХБ-ны хооронд энэхүү өдөр зэрэг байгуулах зээлийн хэлэлцээр ("Хөнгөлөлттэй эх үүсвэрийн зээлийн хэлэлцээр" гэх)-т тусгасан нөхцөл, болзлын дагуу төслийн зорилгоор АХБ-ны ердийн хөрөнгийн эх үүсвэрээс долоон сая ам.доллар (7,000,000 ам.доллар)-ын хөнгөлөлттэй эх үүсвэрийн зээл ("Хөнгөлөлттэй эх үүсвэрийн зээл" гэх) авах хүсэлтийг АХБ-инд ирүүлсэн;

(С) АХБ нь дор дурсан хугацаа, нөхцөлийн дагуу АХБ-ны энгийн капиталын нөөцөөс Зээлдэгчид зээл олгохыг зөвшөөрсөнд,

Үндэслэн:

дараах зүйлүүдийг харилцан тохиролцов. Үүнд:

НЭГ ДҮГЭЭР ЗҮЙЛ

Зээлийн зохицуулалт; Нэр томьёо


Заалт 1.01. АХБ-ны 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн Энгийн үйл ажиллагааны зээл зохицуулах журмын (цаашид "Зээлийн журам" гэх) бүх заалт нь дараах өөрчлөлтийн хамтаар энэхүү Зээлийн хэлэлцээрт шууд заасантай нэгэн адил хүчин төгөлдөр мөрдөгдөнө. Үүнд:

(а) Заалт 2.01 (Нэр томьёо)-ны (хх) дэд хэсгийг устгаж дараах байдлаар бүхэлд нь орлуулна:

(хх) "Жишиг хүү" нь (i) АХБ нь 3.02 (с) -т заасны дагуу Евро, LIBOR-ээс бусад зээлийн валютын талаар болон Евро, Euribor-ын талаар дурдсанаас бусад тохиолдолд; мөн (ii) 3.02 (с) хэсгийн дагуу заасан бол АХБ нь бусад жишиг хүү ба зээлийн валютын тархалтыг үндэслэлтэйгээр тодорхойлж, Зээлдэгч болон Батлан даагчид нэн даруй мэдэгдэх ёстой.

(b) 3.02 (b) дэд хэсгийн дараа дараах шинэ дэд хэсгийг 3.02 (с) дээр оруулна:

Заалт 3.02 (с). Хэрэв зээлийн хүүг LIBOR эсвэл Euribor-ийн үндсэн дээр тооцсон ба АХБ нь (i) холбогдох зээлийн валютад тухайн жишиг хүүг хэрэглэхээ больсон, зохицуулах байгууллагаас тухайн жишиг хүүг хэрэглэхгүй болсон тухай албан мэдэгдлийг хэвлүүлсэн, эсвэл (ii) АХБ нь энэ төрлийн жишиг хүүг өөрийн хөрөнгө болон өр



төлбөрийн удирдлагад арилжааны хувьд хүлээн зөвшөөрөх боломжгүй эсвэл цаашид хэрэглэх боломжгүй тохиолдолд АХБ нь холбогдох зээлийн валютын хувьд ийм өөр жишиг хүүг үндэслэлтэй тодорхойлж хэрэглэнэ. АХБ нь бусад жишиг хүү, аливаа төлөлт, түүнчлэн хэрэгжүүлэхэд шаардагдах Зээлийн хэлэлцээрийн заалтад холбогдох нэмэлт өөрчлөлтийн тухай Зээлдэгч болон Батлан даагчид нэн даруй мэдэгдэх бөгөөд мэдэгдсэн өдрөөс хүчин төгөлдөр болно.

Заалт 1.02. Зээлийн журамд заасан нэр томьёо нь өөрөөр шаардаагүй тохиолдолд энэхүү Зээлийн хэлэлцээрт ижил утгаар хэрэглэгдэнэ. Үүнээс гадна дараах нэмэлт нэр томьёо нь дор дурдсан утгатай байна.

- (a) “Зөвлөх үйлчилгээ” гэдэг нь Худалдан авах ажиллагааны журам, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан, энэ зээл боло хөнгөлөлттэй зээлээс санхүүжүүлэх зөвлөх үйлчилгээг;
- (b) “БОМТ” гэдэг нь БОАҮ-д тусгасан, эдгээрт хийсэн аливаа шинэчлэлийг багтаасан төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг;
- (c) “Байгаль Хамгаалал” гэдэг нь Хамгааллын бодлогын мэдэгдлийн V бүлэг, Хуваарь 1, Хуваарь 4 дээр (холбогдох тохиолдолд) заасан зарчим, шаардлагыг;
- (d) “ЖҮАТ” гэдэг нь Зээлдэгчийн боловсруулж, АХБ-ны тодорхойлсон ба төслийн шинэчлэлийг агуулсан Жендерийн үйл ажиллагааны төлөвлөгөөг;
- (e) “Бараа” гэдэг нь Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан ба Зээлийн хөрөнгөөр санхүүжих тоног төхөөрөмж, материалыг хэлэх ба үүнд зөвлөх бус үйлчилгээтэй холбоотой буюу тээвэрлэлт, даатгал, угсралт, ашиглалтад оруулах, сургалт, анхан шатны засвар үйлчилгээ зэрэг багтана;
- (f) “БОАҮ” гэдэг нь Зээлдэгчийн боловсруулж ирүүлсэн, АХБ-ны баталсан, мөн хийгдсэн өөрчлөлт шинэчлэлийг нь багтаасан төслийн Байгаль орчны анхдагч үнэлгээг;
- (g) “Албадан нүүлгэн шилжүүлэх хамгаалалтын арга хэмжээ” гэж ХБМ-ийн V бүлэг, 2 дугаар хавсралт, 4 дүгээр хавсралтад (холбогдох) заасан зарчим, шаардлагыг хэлнэ.
- (h) “Зээлийн хуваарилалтын журам” гэдэг нь АХБ-ны Зээлийн хуваарилалтын журмыг хэлнэ (2017 онд батлагдаж, нэмэлт өөрчлөлт хийгдсэн);
- (i) “ХХААХҮЯ” гэдэг нь Зээлдэгчийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, эсвэл түүний эрх, үүргийг залгамжлах байгууллагыг;
- (j) “БОАЖЯ” гэдэг нь Зээлдэгчийн Байгаль орчин, аялал жуулчлалын

Арын үсэг /Signature/ 

2022 оны 01 сарын 12 өдөр
Үлсанбаатар хот

OFFICIAL TRANSLATION

яам, эсвэл түүний эрх, үүргийг залгамжлах байгууллагыг;

- (k) “Зөвлөх бус үйлчилгээ” гэдэг нь Худалдан авах ажиллагааны журам, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан, энэ зээл болон хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлсэн зөвлөх бус үйлчилгээг;
- (l) “ТУЖ” гэдэг нь Зээлдэгч болон АХБ харилцан зөвшөөрсөн 2021 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн Төслийн удирдлагын журмыг хэлнэ. Төслийн удирдлагын журамд Зээлдэгч болон АХБ-ны хүлээн зөвшөөрсөн төслийн удирдлагын зарчмуудын дагуу нэмэлт өөрчлөлтийг тухай бүр оруулна;
- (m) “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө” гэдэг нь Зээлдэгч ба АХБ харилцан зөвшөөрсөн 2021 оны 4 дүгээр өдрийн Төслийн худалдан авалтын төлөвлөгөөг хэлнэ. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд Худалдан авах ажиллагааны бодлого, Худалдан авах ажиллагааны журам болон АХБ-тай тохиролцсон бусад нөхцөлийн дагуу тухай бүр өөрчлөлт оруулна;
- (n) “Худалдан авах ажиллагааны бодлого” гэдэг нь АХБ-ны Худалдан авах ажиллагааны бодлого – Бараа материал, ажил, зөвлөх болон зөвлөх бус үйлчилгээ (2017 онд батлагдан, нэмэлт өөрчлөлт хийгдсэн) хэмээх баримт бичгийг;
- (o) “Худалдан авах ажиллагааны журам” гэдэг нь АХБ-ны зээлдэгчдэд зориулсан АХБ-ны Худалдан авах ажиллагааны журам – Бараа материал, ажил, зөвлөх болон зөвлөх бус үйлчилгээ (2017 онд батлагдан, нэмэлт өөрчлөлт хийгдсэн) баримт бичгийг;
- (p) “Төсөл хэрэгжүүлэгч байгууллага” гэдэг нь АХБ-ны 2017 оны 1-р сарын 1-ний өдрийн Энгийн үйл ажиллагааны зээлийн журмын зорилго болон түүний утгын хүрээнд төслийн хэрэгжилтийг хариуцах ХХААХҮЯ эсвэл АХБ-ны хүлээн зөвшөөрөгдсөн аливаа залгамжлагчийг;
- (q) “Төсөл гүйцэтгэгч байгууллага” гэдэг нь Төсөл хэрэгжүүлэх үүрэг бүхий ХХААХҮЯ-ны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар эсвэл түүний эрх, үүргийг залгамжлах АХБ-ны хүлээн зөвшөөрсөн байгууллагыг;
- (r) “Төслийн байгууламж” гэдэг нь төслийн хүрээнд барих, худалдан авах, сэргээн засварлах болон/эсвэл үйл ажиллагааг нь цаашид үргэлжлүүлэн авч явах байгууламжийг;
- (s) “Нүүлгэн шилжүүлэлтийн хүрээ” гэж Зээлдэгчээс бэлтгэж ирүүлсэн, АХБ-наас зөвшөөрөл авсан төслийн нүүлгэн шилжүүлэлтийн хүрээ болон түүний шинэчлэлтийг;
- (t) “Хамгааллын мониторингийн тайлан” гэдэг нь Төсөл хэрэгжүүлэгч байгууллага боловсруулж АХБ-нд ирүүлсэн БОМТ, Нүүлгэн шилжүүлэх хүрээний (хэрэв байгаа бол) хэрэгжилт болон

Хамгааллын үсэг /Signature/ 01

2022 оны 01 сарын 12 өдөр

ҮНДЭС БАДГАР ЭРТ

биелүүлэлтийн явцыг тодорхойлсон, аливаа засан залруулах ба урьдчилан сэргийлэх арга хэмжээг багтаасан тайланг;

- (u) "НХҮАТ" гэж төсөл хэрэгжүүлэхэд зориулан бэлтгэсэн нийгмийн хөгжлийн үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний шинэчлэлт бүхий Төсөл хэрэгжүүлэгч байгууллага болон АХБ хооронд тохиролцсон төлөвлөгөөг;
- (v) "Үйлчилгээ" гэдэг нь зөвлөх ба зөвлөх бус үйлчилгээг хэлнэ;
- (w) "ХБМ" гэдэг нь АХБ-ны Хамгааллын бодлогын мэдэгдлийг (2009); мөн
- (x) "Ажлууд" гэдэг нь Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан бөгөөд Зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх барилгын ажлыг хэлэх ба үүнд түлхүүр гардуулах нөхцөлтэй ажил үүргийн нэг хэсэг болох зөвлөх бус үйлчилгээ, төсөлтэй холбоотой үйлчилгээг тус тус хэлнэ.

ХОЁР ДУГААР ЗҮЙЛ

Зээл

Заалт 2.01. (a) АХБ нь АХБ-ны энгийн капитал хөрөнгийн эх үүсвэрээс Зээлдэгчид хорин гурван сая (23,000,000) ам. долларыг зээлдүүлэхийг зөвшөөрсөн ба зээлийн хөрөнгийг энэхүү зээлийн хэлэлцээрийн 2.06 дугаар хэсгийн заалтын дагуу тухай бүр өөр валютад хөрвүүлэх боломжтой байдлаар олгоно.

(b) Зээлийн үндсэн төлбөрийг эргүүлэн төлөх хугацаа нь 19 жил байх бөгөөд зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацааг дэд хэсэг (c) заалтад тодорхойлов.


(c) Дээрх (b) дэд хэсэгт дурдсан "зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа" гэсэн нэр томъёо нь энэхүү зээлийн хэлэлцээрийн хуваарь 2-т заасан зээлийн үндсэн төлбөрийг эргэх төлөх хуваарийн дагуу зээл эргүүлэн төлж эхлэх анхны товлосон хугацаа хүртэлх үеийг хэлнэ.

Заалт 2.02. Зээлдэгч нь авч ашигласан болон зээлийн эргэн төлөгдөөгүй үндсэн өрийн үлдэгдэлд дараах нийлбэр дүнтэй тэнцэх хэмжээний хүүг АХБ-нд төлнө:

- (a) Лондонгийн банк хоорондын зээлийн хүү (LIBOR);
- (b) Зээлийн журмын 3.02-т заасны дагуу 0.60% -ийг Зээлийн журмын 3.03-т заасан 0.10% -ийг зээлээс хасаж; мөн
- (c) Зээлийн журмын 3.03-т заасан хугацааны төлбөр (maturity premium) 0.10 -тай тэнцүү байна.

Заалт 2.03. Зээлдэгч нь жилд 0.15% -ийн хөрөнгө нөөцлөн баталгаажуулах төлбөр төлнө. Энэхүү төлбөрийг зээлийн хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 60 хоногийн дараа зээлийн нийт хэмжээнд (тухай бүр зээлийн ашигласан хэмжээг хасна) тооцно.

Заалт 2.04. Зээлийн хүү ба бусад төлбөрийг хагас жил тутам жил бүрийн 2



дугаар сарын 15 ба 8 дугаар сарын 15-ны өдөр төлнө.

Заалт 2.05. Зээлдэгч нь зээлийн данснаас ашигласан зээлийн үндсэн өрийг энэхүү зээлийн хэлэлцээрийн хуваарь 2-т заасны дагуу эргүүлж төлнө.

Заалт 2.06. Зээлдэгч нь өрийг зохистой байдлаар удирдах зорилгоор зээлийн нөхцөлийн дараах хөрвүүлгийг хийлгэх хүсэлтийг санал болгож болно:

- (i) Зээлийн ашигласан болон үлдэгдэл, эсвэл ашиглаагүй зээлийн үндсэн өрийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн зээл олгогдсон үндсэн валютаас батлагдсан валютаар солих, хөрвүүлэх;
- (ii) Зээлийн ашигласан болон үлдэгдэл зээлийн үндсэн өрд бүхэлд нь эсвэл хэсэгчлэн хөвөгч хүүгээс тогтмол хүү рүү, эсвэл эсрэгээр тогтмол хүүгээс хөвөгч хүү рүү өөрчлөх; түүнчлэн
- (iii) Хүүгийн түвшний дээд хэмжээ эсвэл хүүгийн баталгааг хөвөгч хүүд тогтоосноор зээлийн ашигласан болон эргэн төлөгдөөгүй зээлийн үндсэн өрд бүхэлд нь эсвэл хэсэгчлэн хөвөгч хүүд хязгаарлалт хийх.

(b) АХБ хүлээн зөвшөөрсөн дээрх заалтын (a)-д үндэслэн хүсэлт гаргасан аливаа өөрчлөлтийг Зээлийн журмын 2.01 (f) -т заасны дагуу "хөрвүүлэлт" гэж үзэх бөгөөд Зээлийн журам V зүйл ба Хөрвүүлгийн журмын дагуу хүчин төгөлдөр үйлчилнэ.

ГУРАВ ДУГААР ЗҮЙЛ

Зээлийн хөрөнгийн ашиглалт


Заалт 3.01. Зээлдэгч нь энэхүү зээлийн хэлэлцээрийн заалтын дагуу зээлийн хөрөнгийг зөвхөн төслийн зардлыг санхүүжүүлэхэд зарцуулна.

Заалт 3.02. Зээлийн хөрөнгийг энэхүү Зээлийн хэлэлцээрийн Хуваарь 3-ын заалтуудын дагуу хуваарилж, зарцуулах ба тус хуваарийг Зээлдэгч болон АХБ-ны хоорондын зөвшөөрлийн дагуу нэмж өөрчилж болно.

Заалт 3.03. АХБ өөрөөр зөвшөөрснөөс бусад тохиолдолд зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх зардлын зүйлийн худалдан авалтыг энэхүү зээлийн хэлэлцээрийн Хуваарь 4 дээр заасны дагуу хийнэ.

Заалт 3.04. Бараа, үйлчилгээ худалдан авахаар зээлийн данснаас зарлагдсан хөрөнгийг зөвхөн дараах зардалд зарцуулна, үүнд:

- (a) АХБ-ны гишүүн улсад үйлдвэрлэсэн бараа, тэдгээрээс нийлүүлсэн үйлчилгээ нь АХБ-наас үе үе худалдан авалтын зөвшөөрөгдсөн эх үүсвэр хэмээн зарласан жагсаалтад хамаарна;



- (b) АХБ-наас үе үе зарлах зөвшөөрөгдөх бусад шаардлагыг хангасан бараа, үйлчилгээ.

Заалт 3.05. Зээлийн журмын 9.02-т заасны дагуу Зээлийн данс хаагдах өдөр нь 2027 оны 12 дугаар сарын 31-ний өдөр эсвэл Зээлдэгч ба АХБ-ны хооронд тусгайлан тохиролцсон өөр өдөр байна.

ДӨРӨВ ДҮГЭЭР ЗҮЙЛ

Тусгай тохиролцоо

Заалт 4.01. Зээлдэгч нь төсөл хэрэгжүүлэх, төслийн барилга байгууламжийг ашиглахад энэхүү Зээлийн хэлэлцээрийн Хуваарь 4 болон Хөнгөлөлтэй эх үүсвэрийн зээлийн хэлэлцээрт тусгагдсан бүх үүргийг өөрөө биелүүлэх буюу бусад этгээд биелүүлж байх арга хэмжээг авна.

Заалт 4.02. (a) Зээлдэгч нь (i) Төслийн тусдаа данс нээж бүртгэл хөтлөх; (ii) Төслийн жилийн санхүүгийн тайланг АХБ-наас хүлээн зөвшөөрсөн санхүүгийн тайлангийн стандартын дагуу жил бүр боловсруулах; (iii) АХБ хүлээн зөвшөөрсөн аудитын стандартын дагуу, мэргэжлийн чадамж, туршлага, ажлын даалгавар нь АХБ-н шалгуурыг хангасан хөндлөнгийн, бие даасан аудитын байгууллагаар жил бүр санхүүгийн тайлангийн аудит хийлгэх; (iv) эдгээр аудит бүрийн хүрээнд аудит хийлгэсэн байгууллагаар санхүүгийн тайлан, зээлийн хөрөнгийн зарцуулалтын талаарх аудитын дүгнэлт бүхий аудитын тайлан болон удирдлагын дүгнэлт (аудитын явцад илэрсэн төслийн дотоод хяналтын алдаа дутагдал илэрсэн бол түүнийг тайлбарласан) гаргуулах; ба (v) холбогдох санхүүгийн жил дуусгавар болсноос хойш 6 сарын дотор АХБ-нд эдгээр аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын тайлан, удирдлагын дүгнэлтийн хуулбарыг Англи хэл дээр ирүүлэх ба АХБ-ны хүсэлтээр эдгээр баримт бичиг, аудиттай холбоотой бусад мэдээллийг цаг тухайд нь гаргаж өгөх.

(b) АХБ нь аудитаар баталгаажуулсан төслийн санхүүгийн тайлан болон санхүүгийн тайланд аудит хийсэн дүгнэлтийг АХБ-ны баталгаажуулсан өдрөөс 14 хоногийн дотор АХБ-ны цахим хуудсанд байршуулж, нийтэд мэдээлнэ.


(c) Төслийн санхүүгийн тайлан, төсөлтэй холбоотой Зээлдэгчийн санхүүгийн аливаа асуудлаар АХБ дээрх (a) (iii) дэд хэсэгт заасны дагуу томилогдсон аудитын байгууллагатай ярилцан хэлэлцэх хүсэлт тавьсан тохиолдолд Зээлдэгч нь аудитын байгууллагад уг хүсэлтийг уламжлан, ярилцах төлөөллийг томилуулна. Зээлдэгч өөрөөр тохиролцоогүй тохиолдолд тэрхүү хэлэлцүүлэгт Зээлдэгчийн эрх бүхий албан тушаалтан заавал байлцана.

Заалт 4.03. Зээлдэгч нь АХБ-ны төлөөлөгчдөд төсөл, Бараа материал, Ажил, Үйлчилгээ болон холбогдох бүртгэл, баримт бичгийг шалгах боломжийг олгоно.

ТАВ ДУГААР ЗҮЙЛ

Зээлийг түр зогсоох; Хугацаанаас нь өмнө эргэн төлөх

Заалт 5.01. Зээлийн журмын 9.01 (м) хэсгийг хэрэгжүүлэх зорилгоор Зээлдэгчийн Зээлийн данснаас санхүүжилт авах эрхийг дараах нэмэлт нөхцөлийн үндсэн дээр түр зогсооно: ЯБЯС-ийн буцалтгүй тусламжийг түр зогсоох буюу цуцлах тохиолдолд.



Заалт 5.02. Зээлийн журмын 9.07(а) (iv) хэсэгт заасан зорилгоор дараах нэмэлт нөхцөлийн үндсэн дээр зээлийн эргэн төлөгдөх хугацааг богиносгоно: Энэхүү Зээлийн хэлэлцээрийн 5.01-р хэсэгт заасан зүйл тохиолдсон нөхцөлд.

ЗУРГАА ДУГААР ЗҮЙЛ

Хүчин төгөлдөр болох

Заалт 6.01. Зээлийн журмын 10.01 (f) хэсэгт заасан зорилгын хүрээнд энэхүү зээлийн хэлэлцээрийн хүчинтэй болох нэмэлт нөхцөл болгон дараахыг тусгасан болно: Зээлдэгч нь хөнгөлөлттэй эх үүсвэрийн зээлийн хэлэлцээрийг зохих ёсоор нь боловсруулж хүргүүлэх ёстой бөгөөд түүний хуулийн дагуу хүчин төгөлдөр болох урьдчилсан бүх нөхцөлүүдийг (энэхүү зээлийн хэлэлцээрийн хүчин төгөлдөр болох нөхцөлөөс бусад) хангасан байна.

Заалт 6.02. Зээлийн журмын 10.04-т заасан зорилгын хүрээнд энэхүү зээлийн хэлэлцээр нь түүнийг байгуулсан өдрөөс хойш 90 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

ДОЛОО ДУГААР ЗҮЙЛ

Бусад зүйл

Заалт 7.01. Зээлийн журмын 12.02-р хэсгийн зорилгоор Зээлдэгчийн төлөөлөгчөөр Сангийн сайдыг томилсон болно.

Заалт 7.02. Зээлийн журмын 12.01-р хэсгийн зорилгоор дараах хаягийг тодорхойлсон болно:

Зээлдэгч:

Сангийн яам, Засгийн
газрын II байр,
С.Данзангийн гудамж 5/1,
Улаанбаатар-15160
Монгол улс

Факсын дугаар:


(976-11) 320247

Азийн Хөгжлийн Банк:

Азийн Хөгжлийн Банк
АХБ-ны өргөн чөлөө 6,
Мандалуйонг хот
1550 метро Манила,
Филиппин улс

Факсын дугаарууд:

(632) 8636-2444




ДЭЭРХИЙГ НОТОЛЖ, талууд зохих ёсоор эрх олгогдсон төлөөлөгчдөөрөө
дамжуулан энэхүү Зээлийн хэлэлцээрийн эхэнд дурдсан өдөр гарын үсэг зурж, АХБ-ны
Төв байранд хүргүүлэв.

МОНГОЛ УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ

[Нэр, албан тушаал]

АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКИЙГ ТӨЛӨӨЛЖ

[Нэр, албан тушаал]



ХУВААРЬ 1

Төслийн тодорхойлолт

1. Төслийн зорилго нь уур амьсгалд дасан зохицох чадвартай мал аж ахуйн бүтээгдэхүүний үр ашиг, тогтвортой байдлыг нэмэгдүүлэхэд оршино.


2. Төсөл дараах үр дүнг агуулсан:

Үр дүн 1: Уур амьсгалд дасан зохицсон мал аж ахуй, бэлчээр, усны менежмент сайжирсан байна. Энэхүү үр дүн нь малын бэлчээрийн даацын хязгаарыг мөрдөх замаар цаг уурын эрс тэс үзэгдлийг даван туулах, малчдын уур амьсгалд дасан зохицох чадварыг бий болгох ба энэ хүрээнд (i) 11660 малчныг хамарсан (нэг нутаг усныханд тулгуурласан) 466 малчны байгууллага, 466 БАГ байгуулах замаар бэлчээрийн менежментийг сайжруулах, малын тооны ачааллыг бууруулах; (ii) 14000 малын байрыг сайжруулах; (iii) 382 худаг шинээр барих, 466 ус ашиглах гэрээг байгуулах замаар малын усны хүртээмжийг сайжруулах; (iv) 466 малчны бүлэгт 14000 хадлангийн талбай, өвсний агуулах байгуулах замаар малын тэжээлийн хангамжийг сайжруулах; (v) 20 сумын бэлчээрийн нөөц газрыг байгуулах.

Үр дүн 2: Мал аж ахуйн нэмүү өртгийн сүлжээг бэхжүүлсэн байна. Энэхүү үр дүнгийн хүрээнд нь мал сүргийн болон бүтээгдэхүүний чанар, эрүүл мэндийн стандартыг сайжруулж, малын нэмүү өртгийн сүлжээнд холбогдох оролцогчдын уялдаа холбоо, зохицуулалтыг сайжруулна. Ингэхдээ (i) (A) эрүүл мэнд, гулуузын чанар зэрэгтэй холбоотой боловсруулагч үйлдвэр, зах зээлийн стандартад нийцүүлэхийн тулд 2915 малчин өрх, боловсруулагч үйлдвэрийг хооронд нь холбох, (B) малчдыг эргэх холбоогоор хангах замаар мал аж ахуйн салбарын маркетингийг сайжруулах; (ii) хадлан бэлтгэх, тэжээл агуулахад дэмжлэг үзүүлэх замаар 466 малчны байгууллагын мал тэжээх үйл ажиллагааг сайжруулах; (iii) 54 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийг дэмжих замаар 11660 малчдын малын эрүүл мэндийг сайжруулах; (iv) хонь, ямааны 20 цөм сүрэг байгуулах замаар мал үржлийн ажлыг сайжруулах; (v) Хурга бордох 20 тэжээлийн нэгжид хурга таргалуулах замаар малын эргэлтийг нэмэгдүүлэх; (vi) ноолуур ангилах сумын 20 байгууламжийг байгуулах замаар ноолуурын борлуулалтыг сайжруулах.

Үр дүн 3: Мал аж ахуйн салбарын зохицуулалтын хүрээ, чадавх сайжирсан байна. Энэ үр дүнгийн хүрээнд мал аж ахуйн зохицуулалтын тогтолцоо, байгууллагын чадавхыг дараах байдлаар бэхжүүлнэ. Үүнд (i) бэлчээрийн менежментийг сайжруулах хууль эрх зүйн орчныг хөгжүүлж, мэдлэг дээшлүүлж, сурталчлах үйл ажиллагааг нэмэгдүүлэх; (ii) (A) Газарзүйн мэдээллийн системд (ГМС) суурилсан Мал аж ахуйн менежментийн мэдээллийн систем (LMIS) болон (Б) ХХААХҮЯ-нд Бэлчээр, тэжээлийн хэлтэс байгуулах; (iii) зах зээлийн жишигт хүрэх зорилгоор гулуузыг мөшгөх, эргэх холбоо тогтоох системийг хөгжүүлэх; (iv) 20 суманд Монгол малын эрүүл мэндийн тогтолцоог (MAHIS) өргөжүүлэх; (v) ХХААХҮЯ-ны Судалгаа хөгжлийн төвийн сургалтын үйлчилгээний чадавхыг сайжруулах; (vi) аймаг дундын гурван бэлчээрийн нөөц газрыг хөгжүүлэх.

3. Төслийг 2027 оны 6 дугаар сарын 30 гэхэд дуусгахаар төлөвлөж байна.



ХУВААРЬ 2


Зээлийн эргэн төлөлтийн хуваарь

1. Дараах хүснэгтэд зээлийн үндсэн төлбөр төлөх огноо болон үндсэн төлбөр төлөх огноо бүрд хамаарах зээлийн үндсэн төлбөрөөс төлөх хувь хэмжээг (хэсэгчилсэн төлбөр) харуулав. Хэрэв зээлийн үндсэн төлбөр төлөх эхний өдөр хүртэл зээлийн хөрөнгийг бүрэн авч зарцуулсан тохиолдолд АХБ нь үндсэн төлбөр төлөх өдөр тус бүрд зээлдэгчийн төлөх зээлийн үндсэн төлбөрийн хэмжээг дараах аргаар тодорхойлно: (а) үндсэн төлбөр төлөх эхний өдрийн байдлаар зээлийн нийт ашигласан болон үлдэгдэл дүнг; (б) Үндсэн төлбөр төлөх өдөр бүрийн төлбөрийн хувь хэмжээгээр үржүүлэн тооцно. Хэрэв шаардлагатай бол энэхүү Хуваарийн 4 дэх хэсэгт заасан Валютын хөрвүүлэг хийгдэх валютын ханшны өөрчлөлтөөс үүдэн гарсан дүнг хасч эргэн төлөлт хийх дүнд өөрчлөлт тохиргоо хийнэ.

Төлбөр хийх хугацаа

Хэсэгчилсэн төлбөр [(%-иар илэрхийлсэн)]

2027 оны 8-р сарын 15	2.631579
2028 оны 2-р сарын 15	2.631579
2028 оны 8-р сарын 15	2.631579
2029 оны 2-р сарын 15	2.631579
2029 оны 8-р сарын 15	2.631579
2030 оны 2-р сарын 15	2.631579
2030 оны 8-р сарын 15	2.631579
2031 оны 2-р сарын 15	2.631579
2031 оны 8-р сарын 15	2.631579
2032 оны 2-р сарын 15	2.631579
2032 оны 8-р сарын 15	2.631579
2033 оны 2-р сарын 15	2.631579
2033 оны 8-р сарын 15	2.631579
2034 оны 2-р сарын 15	2.631579
2034 оны 8-р сарын 15	2.631579
2035 оны 2-р сарын 15	2.631579
2035 оны 8-р сарын 15	2.631579
2036 оны 2-р сарын 15	2.631579
2036 оны 8-р сарын 15	2.631579
2037 оны 2-р сарын 15	2.631579
2037 оны 8-р сарын 15	2.631579
2038 оны 2-р сарын 15	2.631579
2038 оны 8-р сарын 15	2.631579
2039 оны 2-р сарын 15	2.631579
2039 оны 8-р сарын 15	2.631579
2040 оны 2-р сарын 15	2.631579
2040 оны 8-р сарын 15	2.631579
2041 оны 2-р сарын 15	2.631579
2041 оны 8-р сарын 15	2.631579
2042 оны 2-р сарын 15	2.631579



2042 оны 8-р сарын 15	2.631579
2043 оны 2-р сарын 15	2.631579
2043 оны 8-р сарын 15	2.631579
2044 оны 2-р сарын 15	2.631579
2044 оны 8-р сарын 15	2.631579
2045 оны 2-р сарын 15	2.631579
2045 оны 8-р сарын 15	2.631579
2046 оны 2-р сарын 15	2.631577

Нийт

100.000000


2. Хэрэв зээлийн Үндсэн төлбөр төлөх эхний өдөр гэхэд зээлийн хөрөнгийг бүрэн авч ашиглаагүй бол Үндсэн төлбөр төлөх өдөр бүр зээлдэгчийн төлөх зээлийн үндсэн төлбөрийн хэмжээг дараах байдлаар тооцно:

- (a) Зээлийн үндсэн төлбөр төлж эхлэх өдөр хүртэл зээлийн зарцуулалт хийсэн хэмжээгээр Зээлдэгч нь нийт зарцуулсан зээл болон үлдэгдэл дүнг энэхүү хуваарийн 1 дээр заасны дагуу буцаан төлнө; түүнчлэн
- (b) Үндсэн төлбөр төлж эхлэх өдрөөс хойш хийсэн зээлийн аливаа зарцуулалтын үндсэн төлбөрийг АХБ-наас тооцсон дүнгээр төлбөр төлөх хуваарьт өдөр төлнө. Үндсэн төлбөр төлөх өдөр бүр зарцуулсан хэмжээ бүрийг энэхүү хуваарийн 1 дүгээр хэсгийн хүснэгтэд заасан тухайн өдрийн хэсэгчлэн төлөх хувиар үржүүлж, зарцуулалт хийсэн өдөр буюу түүнээс хойш үндсэн төлбөр төлөх өдрүүдийн үлдсэн бүх хэсэгчилсэн төлбөрүүдийн нийлбэрт хувааж тооцно. Уг төлбөр хийх дүнгээс шаардлагатай тохиолдолд энэхүү хуваарийн 4 дэх хэсэгт заасан валютын хөрвүүлэгтэй холбоотой дүнг хасаж өөрчлөлт тохируулна хийнэ.

3. Үндсэн төлбөр төлөх аль нэг өдрөөс өмнө хуанлийн 2 сар хүртэлх хугацаанд хийсэн зарцуулалтыг, зөвхөн үндсэн төлбөр төлөх өдрийн төлөх хэмжээг тооцох үүднээс, зарцуулалт хийснээс хойш 2 дахь үндсэн төлбөр төлөх өдөр ашигласан болон үлдэгдэл дүнд тооцох бөгөөд түүний зарцуулалт хийсэн өдрөөс хойш 2 дахь үндсэн төлбөр төлөх өдрөөс эхлэн үндсэн төлбөр төлөх өдөр бүр төлнө.

4. Энэхүү хуваарийн 1, 2 дахь хэсгийн заалтыг үл харгалзан зээлийн үндсэн хөрөнгийг бүхэлд нь буюу хэсэгчлэн батлагдсан валют руу хөрвүүлсний дараа, хөрвүүлэг хийсэн хугацаан дахь аливаа үндсэн төлбөр төлөх өдөр буцааж төлөх дүнг АХБ нь дараах байдлаар тодорхойлно: Үүнд дээрх хөрвүүлэг хийсэн дүнг дараах үзүүлэлтүүдийн аль нэгээр үржүүлнэ: (a) тухайн хөрвүүлэгтэй холбоотой АХБ-ны валютын ханшны эрсдэлийн хамгаалах түвшинд заагдсан ханшаар баталсан валютаар илэрхийлсэн үндсэн төлбөрийн хэмжээг тусгасан валют солилцооны ханш; эсвэл (б) Хөрвүүлгийн журмын дагуу АХБ-с шийдвэрлэсэн тохиолдолд Дэлгэцийн ханшаар буюу стандарт зах зээлийн хүүгээр.

5. Зээлийн ашигласан болон үлдэгдэл үндсэн төлбөрийг нэгээс дээш валютаар хийсэн тохиолдолд ашигласан валют тус бүрд эргэн төлөлтийн хуваарь бий болгох үүднээс энэхүү хуваарийн заалтууд тусдаа хэрэглэгдэнэ.



ХУВААРЬ 3

Зээлийн хөрөнгийн хуваарилалт ба зарцуулалт

Ерөнхий Зүйл

1. Зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх зардлын ангилал болон Зээлийн хөрөнгөөс тэдгээр ангилал тус бүрд хуваарилсан санхүүжилтийн хэмжээг энэхүү хуваарьт хавсаргасан хүснэгтэд (цаашид "Хүснэгт" гэх) харуулсан болно. (Энэхүү хуваарьт дурдсан "ангилал" гэж Хүснэгт дэх "ангилал" эсхүл "дэд ангиллыг" илэрхийлнэ.)

Зээлийн данснаас мөнгө шилжүүлэх (татан авах) нөхцөл

2. АХБ тусгайлан зааснаас бусад тохиолдолд Хүснэгт дэх ангилал бүрийн зардлыг Зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэхдээ Хүснэгтэд тодорхойлсон хувь хэмжээг баримтална.

Зээлийн хүү ба зээл олгосны төлбөр

3. "Зээлийн хүү ба зээл олгосны төлбөр" ангилалд хуваарилагдсан мөнгөн дүн нь Төсөл хэрэгжүүлэх хугацааны туршид Зээлийн хүү, зээл олгосны төлбөрийг төлөхөд зарцуулагдана. АХБ нь зээлийн хүүгийн болон зээл олгосон төлбөрт шаардагдах төлбөрийг Зээлдэгчийн нэрийн өмнөөс Зээлийн данснаас татан авч, төлбөр хийх эрхтэй.


Дахин хуваарилалт

4. Зээлийн хөрөнгийн хуваарилалт болон Хүснэгтэд заасан санхүүжилтийн хувь хэмжээг үл харгалзан:

- (a) Хэрэв аль нэг ангилалд зарцуулагдах Зээлийн хэмжээ нь тухайн ангиллын хүрээнд шаардагдах зардлыг санхүүжүүлэхэд хүрэлцэхгүй байгаа бол АХБ нь Зээлдэгчид урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр: (i) өөр Ангилалд хуваарилагдсан бөгөөд АХБ-ны үзсэнээр бусад зардлыг санхүүжүүлэхэд шаардлагагүй хөрөнгийг дутагдаж буй бүрэлдэхүүн ангилалд дахин хуваарилалт хийх, (ii) хэрэв дахин хуваарилагдсан хөрөнгө нь дутагдаж буй хэмжээг нөхөхөд хүрэлцэхгүй бол тухайн Ангиллын хүрээнд хийгдэх бусад бүх зарцуулалтыг үргэлжлүүлэх үүднээс анх хөрөнгө дутагдсан зүйлд зарцуулахаар төсөвлөсөн хөрөнгийн хувь хэмжээг багасгах; болон
- (b) Хэрэв тухайн Ангилалд хуваарилагдсан эх үүсвэр нь уг ангиллын хувьд тохиролцсон шаардлагатай бүх зардлын хэмжээнээс илүү гарвал АХБ Зээлдэгчид урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр илүү гарсан хөрөнгийг өөр Ангилалд дахин хуваарилна.

Зарцуулалт хийх журам

5. АХБ өөрөөр зөвшөөрснөөс бусад тохиолдолд зээлийн хөрөнгийг АХБ-ны "Зээлийн хуваарилалтын журмын" дагуу зарцуулна.




ХҮСНЭГТ

ЗЭЭЛИЙН ХӨРӨНГИЙН ХУВААРИЛАЛТ БА ЗАРЦУУЛАЛТ			
Дугаар	Зүйл	АХБ-аас санхүүжилтэд хуваарилсан нийт дүн (ам доллар)	Зээлийн данснаас гаргах санхүүжилтийн хувь
		Ангилал	
1	Ажил болон Бараа ^а	13,344,599	Нийт зардлын 100% ^б
2	Үйлчилгээ ^а	2,394,948	Нийт зардлын 100%
3	Урсгал зардал ^а	4,095,734	Нийт зардлын 100%
4	Хүү болон хөрөнгө нөөцлөн баталгаажуулсан төлбөр	913,036	Нийт төлбөрийн 100%
5	Хуваарилагдаагүй	2,251,683	
	НИЙТ	23,000,000	

а Харгалзах ангилалд зориулж энэхүү зээлийг олгохоос өмнө хөнгөлөлттэй эх үүсвэрийн зээлийн хөрөнгийг бүрэн зарцуулсан байна.

б. Зээлдэгчийн нутаг дэвсгэрт багтсан ажил, барааны нэмэгдсэн өртгийн албан татвар, хураамжийг хасаж тооцно.



ХУВААРЬ 4

Төслийн гүйцэтгэл; Санхүүгийн асуудлууд

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Зээлдэгч нь Төсөл хэрэгжүүлэгч байгууллагаар дамжуулан ТУЖ дээр заасан нарийвчилсан зохицуулалтын дагуу төсөл хэрэгжиж байгаа эсэхийг баталгаажуулна. ТУЖ-д хийгдсэн аливаа өөрчлөлтийг Зээлдэгч ба АХБ-наас зөвшөөрсний дараа тухайн өөрчлөлт хүчин төгөлдөр болно. ТУЖ ба энэхүү зээлийн хэлэлцээр хооронд ямар нэгэн зөрүү гарсан тохиолдолд энэхүү зээлийн хэлэлцээр болон хөнгөлөлттэй эх үүсвэрийн зээлийн хэлэлцээрийн заалтыг дагаж мөрдөнө.

Худалдан авалт


2. Зээлдэгч нь Төсөл хэрэгжүүлэгч байгууллагаар дамжуулан дараах зүйлийг баталгаажуулна:

- (a) Бараа материал, ажил болон үйлчилгээний худалдан авалт нь Худалдан авах ажиллагааны бодлого болон Худалдан авах ажиллагааны журмын дагуу явагдана;
- (b) Бараа материал, ажил, үйлчилгээг Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан нарийвчилсан зохицуулалтын дагуу худалдан авах ба үүнд худалдан авах, сонгон шалгаруулах арга, тендерийн баримт бичгийн төрөл, болон АХБ-ны хянах шаардлагууд багтана. Зээлдэгч нь Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан нарийвчилсан зохицуулалтыг зөвхөн АХБ-тай урьдчилан тохиролцсоны дагуу өөрчилж болох бөгөөд ийм өөрчлөлтийг Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний шинэчлэлд тусгасан байх; мөн
- (c) (i) Худалдан авсан бүх Бараа материал, Ажил, Үйлчилгээ (үүнд компьютерын бүх техник хангамж, программ хангамж ба систем хамтад нь эсвэл тусад нь худалдаж авсан эсвэл бусад бараа, үйлчилгээтэй хамт худалдан авсан эсэхээс үл хамааран) гуравдагч этгээдийн үйлдвэрлэлийн болон оюуны өмчийн эрхийг хөндөөгүй, зөрчөөгүй байх; мөн (ii) Бараа материал, ажил, үйлчилгээ, худалдан авахтай холбоотой бүх гэрээнд энэхүү дэд хэсэгт дурдсан зохих мэдэгдэл, баталгаа болон шаардлагатай тохиолдолд гүйцэтгэгч, нийлүүлэгч, зөвлөх эсвэл үйлчилгээ үзүүлэгчээс зохих тайлбар өгөх, хохирол барагдуулах баталгааг тусгасан байх .

Гэрээ байгуулах нөхцөл

3. Зээлдэгч нь төсөл хэрэгжүүлэгч байгууллагаар дамжуулан байгаль орчинд нөлөөлөх аливаа ажил гүйцэтгэх гэрээг дараах нөхцөл биелэгдэх хүртэл байгуулахгүй:

- (a) Төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь БОМТ-ийн холбогдох заалтыг гэрээнд



- тусгах;
- (b) Байгаль орчны үнэлгээнд тавигдах дотоодын шаардлагуудыг дотоодын холбогдох байгууллагууд гүйцэтгэсэн; болон
 - (c) Байгаль орчны үнэлгээг дотоодын холбогдох байгууллагууд баталж, АХБ баталгаажуулсан байх.

Зээлдэгч талын дэмжлэг

4. Зээлдэгч нь Төсөл хэрэгжүүлэгч байгууллага болон төсөл гүйцэтгэгч байгууллага нь Төслийг хэрэгжүүлэх явцад гарсан хөрөнгийн дутагдал, зардлын хэтрэлт зэрэгт шаардагдах, төслийг саадгүй, үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгөтэй байх болон эдгээр бүх хөрөнгийг цаг тухайд нь гаргах боломжтой байхыг баталгаажуулна. Зээлдэгч нь мөн Төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь төслийн барилга байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээнд шаардагдах төсвийн болон бусад хангалттай нөөцийг цаг тухайд нь хуваарилж, шуурхай хангахыг баталгаажуулна.
5. Дээр дурдсанаас гадна Зээлдэгч нь Төсөл хэрэгжүүлэгч байгууллага болон Төсөл гүйцэтгэгч байгууллагыг аливаа ажил, бараа, үйлчилгээний гэрээнээс үүсэх өр төлбөрийг барагдуулах хангалттай санхүүжилт байгаа эсэхийг бататгана.


Хамгаалалт

Байгаль орчин

6. Зээлдэгч нь Төсөл хэрэгжүүлэгч байгууллагаар дамжуулан төсөл болон бүх төслийн байгууламжийн бэлтгэл, зураг төсөл, барилга угсралт, гүйцэтгэл, ашиглалт ба татан буулгах ажлыг дараах баримт бичгүүдэд заасантай нийцүүлж явуулна: (a) Зээлдэгчийн байгаль орчин, эрүүл ахуй, аюулгүй байдалтай холбоотой бүх хууль тогтоомж, дүрэм журам; (б) Байгаль орчны хамгаалалт; ба (в) БОАҮ, БОМТ-д тусгагдсан бүх арга хэмжээ, шаардлага, мөн түүнчлэн засаж залруулах ба урьдчилан сэргийлэх арга хэмжээ (i) Хамгааллын хяналт шинжилгээний тайланд тусгагдсан, эсвэл (ii) АХБ ба Зээлдэгчийн хооронд тохиролцсон арга хэмжээ.

7. Зээлдэгч нь төслийг хэрэгжүүлэх явцад хийгдэх дотоодын байгаль орчны суурь үнэлгээний үр дүн, төслийн холбогдох бүрэлдэхүүн хэсгүүдийн нарийвчилсан зураг төслийг цаг тухайд нь АХБ-нд тайлагнахыг Төсөл хэрэгжүүлэгч байгууллагаар дамжуулан баталгаажуулна. Төслийн ийм бүрэлдэхүүн хэсэг нь (a) экологийн болон өвийн үнэ цэнэ, ялангуяа тусгай хамгаалалттай газар нутагт сөрөг нөлөө үзүүлэхгүй байх; (б) гүний усны тогтворгүй олборлолт үүсгэхгүй; (в) хүн, мал аж ахуйн холбогдолтой байгууламжийн бохир ус ба/эсвэл хатуу хог хаягдлын менежментээс үүсэх сөрөг нөлөө байхгүй байх тухай тодорхой баталгааг багтаасан байна.

8. Зээлдэгч нь Төсөл хэрэгжүүлэгч байгууллагаар дамжуулан (i) дотоодын байгаль орчны нөлөөллийн үнэлгээ эсвэл (ii) БОМТ-д тусгагдаагүй дотоодын зөвшөөрөл олгох үйл явцыг явцад тодорхойлогдсон аливаа нөхцөл байдлыг хангах БОМТ-д нэгтгэн тусгана. Зээлдэгч нь Төсөл хэрэгжүүлэгч байгууллагаар дамжуулан эдгээр нөхцлийг барилгын холбогдох тендер, тендерийн баримт бичигт шууд тусгана.



9. Зээлдэгч нь Төсөл хэрэгжүүлэгч байгууллагаар дамжуулан дотоодын байгаль орчны нөлөөллийн үнэлгээ болон дотоодын зөвшөөрлийн үйл явц дууссаны дараа аливаа ажил эхлэхээс өмнө дотоодын байгаль орчны суурь үнэлгээний хураангуй дүгнэлт болон байгаль орчны зөвшөөрлийн дүгнэлтийн хураангуйг (англи хэл рүү орчуулсан) АХБ-нд цаг тухайд нь гаргаж өгөхийг баталгаажуулна. БОМХ-д тусгагдаагүй хамгаалалтын шинэ эрсдэл болон/эсвэл эрсдэлийг бууруулах арга хэмжээ эсвэл зардлын талаар аливаа дүгнэлтийг Төсөл хэрэгжүүлэгч байгууллага, БОАЖЯ болон АХБ тохиролцоно.

10. Зээлдэгч нь Төслийн хүрээнд хэрэгжиж буй аливаа Төслийн байгууламж, үйл ажиллагаанд "R134a"-ийг хөргөх бодис болгон ашиглахгүй байхыг Төсөл хэрэгжүүлэгч болон гүйцэтгэгч байгууллагад үүрэг болгоно. Зээлдэгч нь Төсөл хэрэгжүүлэгч байгууллагад (i) энэхүү тусгай шаардлагыг барилгын холбогдох тендерт шууд тусгах; (ii) шалгарсан тендер энэ шаардлагыг хангасан эсэхийг тодорхой үнэлдэг байх шаардлага тавина.


11. Зээлдэгч нь Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын I, II ангилалд аюултай гэж бүртгэгдсэн, эсхүл хэрэглэхийг хатуу хориглосон мөн Зээлдэгчийн хууль тогтоомжийн дагуу хатуу хяналттай буюу хориглосон химийн бодисыг төслийг хэрэгжүүлэхэд ашиглахгүй байхыг Төсөл хэрэгжүүлэгч болон гүйцэтгэгчид даалгана.

12. Зээлдэгч Төсөл хэрэгжүүлэгч байгууллагаар дамжуулан Төслийн хүрээнд баригдсан эсвэл шинэчлэгдсэн бүх усны худгийн хувьд дараах нөхцөл хангасан байхыг баталгаажуулах ба үүнд: (а) хамгийн боломжтой өгөгдөлд үндэслэн уст давхаргын хэмжээ, эргэж сэргэх хурд, одоо байгаа олборлолтын эрэлт, хуримтлагдсан эрэлт, түүний дотор төслийн шаардлагууд зэргийг багтаан газрын доорхи усны тогтвортой байдлыг үнэлнэ; (б) усны худгийн насос бүрт хэмнэлттэй усны тоолуур суурилуулсан байх; (в) газрын доорхи усны олборлолтын хэмжээ, усны ёроолын гүнд тухайн орон нутаг (сум)-ын засаг захиргаа, эрх бүхий байгууллагаас дор хаяж улирал тутам хяналт хийж байх; ба (в) хяналтын үр дүнг Хамгаалалтын хяналтын тайланд тусгана. Гүний усны хүртээмж буурч байгаа тохиолдолд Зээлдэгч нь Төсөл хэрэгжүүлэгч байгууллагаас тус нөхцөл байдлын талаар АХБ-д цаг тухайд нь мэдээлж, зөвшилцөхийг шаардана. Үүний дараа Зээлдэгч нь Төсөл хэрэгжүүлэгч байгууллагаар дамжуулан шаардлагатай засч залруулах буюу урьдчилан сэргийлэх хугацаатай арга хэмжээг бэлтгэж, АХБ-ны зөвшөөрлийг авахаар хүргүүлнэ.

13. Зээлдэгч нь Төсөл хэрэгжүүлэгч байгууллагаар дамжуулан мал аж ахуйн байгууламжийн хувь үйл ажиллагаа эрхлэн явуулагчид хатуу болон шингэн хог хаягдлын менежмент, байнгын хяналттай байхыг баталгаажуулна. Зээлдэгч нь Төсөл хэрэгжүүлэгч байгууллагаар дамжуулан БОМТ-д заасан гадаргын болон гүний усны мониторингийн шаардлагыг шаардлагатай бол төслийн холбогдох бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр хэрэгжүүлэх бөгөөд усны нөөцийг мал аж ахуйн байгууламжийн хог хаягдлаар бохирдуулахгүй байхыг баталгаажуулна.

Төслийн байгууламжийн байршлыг сонгох шалгуур

14. Төслийн тогтвортой байдал болон байгаль орчны хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхийн тулд Зээлдэгч нь Төсөл хэрэгжүүлэгч байгууллагаар дамжуулан Төслийн байгууламжийн байршлыг дараах шалгуурыг хангасан эсэхийг баталгаажуулна.




- (a) Бүх үйл ажиллагаа нь малын бэлчээр болон хөдөө аж ахуйн зориулалтаар ашиглагдаж байсан газруудаар хатуу хязгаарлагдана. Төсөлд газар өөрчлөх, шинээр бэлчээрийн газар байгуулахгүй байх;
